



МАЙНИНГ ТЕХНОЛОГИ ЭНД ЭКУЙПМЕНТ ХХК-ИЙН  
ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН НУТАГ  
ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ  
ТӨСЛИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Улаанбаатар хот  
2023 он

## АГУУЛГА

Хүснэгтийн жагсаалт .....	1
Фото-зургийн жагсаалт .....	2
<b>ОРШИЛ.....</b>	<b>3</b>
<b>БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА .....</b>	<b>4</b>
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл.....	4
1.1.1 Төслийн нэр:.....	4
1.1.2 Төсөл хэрэгжүүлэгч: .....	4
1.1.3 Төслийн байршил .....	4
1.1.4 Хүчин чадал .....	4
1.1.5 Ажиллах хүч.....	4
1.1.6 Барилга байгууламж .....	4
1.1.7 Дэд бүтэц.....	4
1.1.8 Хог хаягдал .....	4
1.2 Химийн бодисын агуулах .....	4
1.3 Химийн бодисын агуулахын үйл ажиллагаа .....	5
1.4 Хөдөлмөр аюулгүй ажиллагаа .....	8
<b>БҮЛЭГ 2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт .....</b>	<b>9</b>
<b>БҮЛЭГ 3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт .....</b>	<b>11</b>
<b>БҮЛЭГ 4. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (2023 он) .....</b>	<b>13</b>
4.1 Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт .....	13
4.2 2023 оны БОМТ-ний зардлын хураангуй .....	13
4.3 2023 оны Сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөө.....	14
4.3.1 Орчны тохижилтын төлөвлөгөө .....	17
4.3.2 Нүүлгэн суурьшуулах арга хэмжээний төлөвлөгөө.....	17
4.3.3 Соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	17
4.3.4 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	18
4.3.5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	19
4.3.6 Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ .....	22
4.4 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	23
4.5 БОМТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ.....	26

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1-1. Химийн бодисын агуулахад хадгалагдах химийн бодисууд.....	6
Хүснэгт 3-1 Нөлөөллийн үнэлгээ.....	11
Хүснэгт 4-1. Химийн бодисын агуулахын 2023 оны БОМТ-ын хэрэгжилтийн зардал .....	13
Хүснэгт 4-2. 2023 оны тухайн жилийн сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөө .....	14
Хүснэгт 4-3. 2023 оны орчны тохижилтын төлөвлөгөө.....	17
Хүснэгт 4-4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	18

Хүснэгт 4-5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	20
Хүснэгт 4-6. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, 2023 он.....	22
Хүснэгт 4-7. 2023 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	24
Хүснэгт 4-8. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь .....	26

#### **ФОТО-ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

Фото-зураг 1-1. Химийн бодисын агуулах .....	5
Фото-зураг 1-2. Химийн бодис агуулах өрөө .....	5
Фото-зураг 1-3. Химийн бодисын савлагаа, 1 тонн /IBC/ .....	5
Фото-зураг 1-4. Анхны тусламжийн өрөө.....	8
Фото-зураг 1-5. Аюулгүй ажиллагааны хамгаалалтын хувцас.....	8

## ОРШИЛ

Майнинг Технологи Энд Экуйпмент ХХК нь 2008 онд гадаад худалдаа, аялал жуулчлалын чиглэлээр үүсгэн байгуулагдсан ба одоогоор химийн бодисын нийлүүлэлт болон үл эвдэх сорилтын туршилт, шинжилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Өмнөговь аймгийн Ханбогд сумын Жавхлант багийн нутаг дэвсгэрт Оюу Толгой уурхайн үйл ажиллагаанд ашиглагдах химийн бодисыг ханган нийлүүлэх мөн Өмнөговь аймаг дахь уул уурхайн компаниудад ижил төрлийн химийн бодис ханган нийлүүлдэг бусад байгууллагууд химийн бодисын тээвэрлэлтийн үедээ түр дамжин өнгөрөх, химийн бодисоо түр хадгалах зориулалтаар химийн бодисын агуулахыг барьж байгуулан 2016 оноос хойш Ханбогд суманд 10 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Майнинг Технологи Энд Экуйпмент ХХК-ийн “Химийн бодисын агуулах” төслийн 2023 оны тухайн жилийн байгаль орчны төлөвлөгөөг боловсрууллаа. Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 өдрийн А/618 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам болон уг төслийн 2021 онд батлагдсан 2021-2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд үндэслэн боловсруулав.

## БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

### 1.1 ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

- 1.1.1 Төслийн нэр: **“Майнинг Технологи Энд Экуйпмент” ХХК-ийн Химийн бодисын агуулах төсөл**
- 1.1.2 Төсөл хэрэгжүүлэгч: ✓ Улсын бүртгэлийн дугаар: 9011145057  
✓ Регистрийн дугаар: 5213045
- 1.1.3 Төслийн байршил: Өмнөговь аймгийн Ханбогд сумын Жавхлант багийн нутаг, Тэмээн ус нэртэй газарт байрлана
- 1.1.4 Хүчин чадал: 30 төрлийн химийн бодисыг агуулах
- 1.1.5 Ажиллах хүч: **Тус агуулах нь нийт 10 ажилтантай. Үүнд Үүнд:** Захирал - 1, Оффис менежер -1 Жолооч-1, Харуул -1, Нярав-1, Нягтлан -2, Тогооч -1, Агуулахын ажилтан - 2
- 1.1.6 Барилга байгууламж: Төслийн нийт талбай нь 0.5 га ба үндсэн байгууламжууд нь:  
✓ Химийн бодисын агуулах – 1000 м<sup>2</sup>  
✓ Анхны тусламжийн өрөө – 30м<sup>2</sup>  
✓ Ачих буулгах тавцан - 350 м<sup>2</sup>  
✓ Бетонон зам – 60\*20м байна.
- 1.1.7 Дэд бүтэц: Цахилгаан хангамж: Нарны эрчим хүч  
Дулаан хангамж: Цахилгаан эрчим хүч  
Ус хангамж: Өөрийн эзэмшлийн 1 худгаас
- 1.1.8 Хог хаягдал: Төслийн ажилчдын хэрэглээнээс хоногт 3 кг, жилд 1.08 тн хатуу хог хаягдал гардаг. Харин шингэн хог хаягдал хоногт 0.63 м<sup>3</sup>, жилд 35.28 м<sup>3</sup> гардаг.

Тус агуулах нь Өмнөговь аймгийн Ханбогд суманд байрладаг. Аюулгүй ажиллагааны бараа бүтээгдэхүүн болон бусад химийн бодисыг технологийн дагуу хадгалдаг ба энэхүү үйл ажиллагаатай холбоотой татвар, хураамжийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, орон нутгийн иргэдийг ажлын байраар хангаж, Ханбогд сумын хөгжилд бодитой дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

### 1.2 ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ

Химийн бодисын агуулахын нийт хэмжээ нь 1000 м<sup>2</sup> талбайтай дөрвөн хэсэг агуулах, 350 м<sup>2</sup> бараа ачиж буулгах тавцан, 60\*20 м бетонон зам, 30 м<sup>2</sup> талбай бүхий анхны тусламжийн өрөөг байгуулсан. Тус агуулахын барилгын суурийг цутгамал төмөр бетоноор цутгасан, барилгын хана 480 мм зузаантай ба MNS 0831:2001-ийн шаардлагыг хангасан 500 кг/м<sup>3</sup> эзлэхүүн жинтэй 380 мм-ийн тоосго өрж гадна талаас 100 мм зузаан хөөсөн полистрол хавтангаар дулаалсан.



Фото-зураг 1-1. Химийн бодисын агуулах

### 1.3 ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тус агуулах нь Өмнөговь аймаг дахь уурхайнуудад химийн бодис нийлүүлэгч байгууллагуудад зориулан химийн бодисыг түр хадгалах, дамжин өнгөрөөх агуулахын үйл ажиллагаа эрхэлдэг.

Одоогоор химийн бодисуудыг Оюу толгой ХХК-д нийлүүлдэг бөгөөд мөн агуулахын зарим хэсгийг бусад компанид түр хугацаагаар түрээслэн ашиглуулдаг. Оюу толгой ХХК өөрсдийн хэрэгцээ шаардлага болон улирлаас хамааран янз бүрийн хугацааны давтамжтайгаар өөрсдийн унаагаар ирж авдаг.

Химийн бодисуудыг Сүхбаатар, Замын-Үүд, Чингис хаан, Алтанбулаг боомтуудаар оруулж ирж байна. Эдгээр химийн урвалжуудыг БНХАУ-ын Inner Mongolian Batuohon Trading ХХК, Binzhou Chengli Building Materials зэрэг компаниудаас гэрээний дагуу худалдан авч байгаа бөгөөд химийн бодисын хадгалалт тээвэрлэлтийг стандартын дагуу гүйцэтгэдэг.

Химийн бодисын агуулахад бодис бүрийн шинж чанарыг харгалзан өөр, өөр өрөөнд дээрх зурагт үзүүлсний дагуу эгнүүлэн хадгалдаг.




Фото-зураг 1-2. Химийн бодис агуулах өрөө

Тус агуулах нь химийн бодис түр хадгалах дөрвөн тустай өрөө (Фото-зураг 1-2) бүхий агуулахтай бөгөөд шингэн болон хатуу төлөвтэй бодисуудыг стандартын дагуу тус, тусад нь ангилан хадгалдаг. Агуулахад хадгалагдах химийн бодисуудын сав баглаа бодлын хувьд 1 төрлийн савлагаатай /IBC/ байна. Химийн бодисын савлагааг доорх Фото-зураг 1-3-д үзүүлээ.



Фото-зураг 1-3. Химийн бодисын савлагаа, 1 тонн /IBC/

Химийн бодисын сав баглаа боодлын хог гарсан тохиолдолд, хаягдлыг түр хугацаанд хадгалж байгаад Цэцүүх Трейд ХХК-д нийлүүлнэ.

Агуулахад хадгалагддаг бодисуудын жагсаалтыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1-1. Химийн бодисын агуулахад хадгалагдах химийн бодисууд

№	Олон улсын нэршил	Монгол нэр	Химийн томъёо	CAS дугаар	НҮБ-ийн дугаар	Агуулахад хадгалах бодисын хэмжээ /тн/		Нэг удаад агуулахад байх хэмжээ /тн/
						1 жилд	3 жилд	
1	AEROPHINE®3418A Promoter	АЕРОФИН®3418 цуглуулагч	$C_8H_{18}NaPS_2 + C_{12}H_{27}PS$	13360-78-6 3982-87-4	3261	900	2700	113
2	ANTIPREX®D	Акрилийн натри	$C_3H_3O_2NA$	7446-81-3	-	800	2400	100
3	WTS 5-0017	Цайрын хлорид Фосфорын хүчил Бусад аюулгүй хольц	$ZnCl_2-H_3PO_4$	7646-85-7 7664-38-2 Аюулгүй	3264	50	450	19
4	WTS 5-1125	Натрийн Толиприазол Бусад аюулгүй хольц	NaOH	64665-57-2 Аюулгүй	1719	50	150	20
5	Dowfroth 250-D	Dowfroth 250-D флотацийн хөөсрүүлэгч	$CH_4O(C_3H_6O)_n$	37286-64-9	-	5	15	1
6	HYPERFLOC® MG 653	Анионы төрлийн акриламидын		-	-	800	2400	100
7	MAGNAFLOC®5250 (AU)	Полиакриламид, анион		-	-	800	2400	104
8	MIBC F500	Фломин Ф 500 хөөсрүүлэгч	$(CH_3)_2CHCH_2CH(OH)CH_3$	108-11-2	2053	900	2700	113
9	WTS 7-106	Хлорын уусмал	$NaClO_2$	7758-19-2	1908	700	2100	60
10	Sodium Dodecyl Sulfate	Натрийн додецилсульфат	$CH_3(CH_2)_{11}SO_4Na$	68018-81-2		50	150	6
11	Chlorine Dioxide solution	Хлорын Давхар Ислийн Уусмал	$ClO_2-HCl$	7647-01-0 7732-18-5	-	50	150	6
12	WTS 9-33	Хлорт устөрөгчийн уусмал	HCl	7647-01-0	1789	5	15	1
13	Magnafloc 338	Өтгөрүүлэгч урвалж	$NH_2CONH_2$	57-13-6	-	400	1200	50
14	3D TRASAR® 3DT120	Хөргөлтийн ус цэвэрлэгч		-	-	5	15	1
15	3D TRASAR® 3DT180	Зэврэлтээс хамгаалагч		-	-	5		1
16	OREPREP OTZ-100 FROTHER	Флотацийн урвалж	$C_8H_{16}O_2 + CH_2=CHCHO$	-	3082	50	150	6
17	Ксантогенат PAX	Цуглуулагч урвалж	$C_6H_{11}KOS_2$	-	-	800	2400	100
18	Calcium chloride	Кальцийн хлорид	$CaCl_2$	10043-52-4 Аюулгүй	-	300	900	100
19	Sodium Alpha Olefin	Натрийн тетрадекан сульфонат	$C_nH_{2n-1}SO_3Na (N=14-16)$	68439-57-6	-	50	150	20
20	Hydrochloric acid	Хлорт устөрөгчийн уусмал	HCl	7647-01-0	-	50	150	10
21	Methanol	Метанол	$CH_3OH$	67-56-1	-	10	30	10
22	Isopropyl Ethylthiocarbamate	Цуглуулагч урвалж IPETC	$C_6H_{13}NOS$	141-98-0	-	300	900	50
23	Sulphide sodium	Хүхэрт натри	$Na_2S$	1313-82-2	-	1000	3000	125
24	Ethylene glycol	Этиленгликоль	$C_2H_6O_2$	107-21-1	-	200	600	63

25	Sodium tetraborate decahydrate	Бура	$\text{Na}_2[\text{B}_4\text{O}_5(\text{OH})_4] \cdot 8\text{H}_2\text{O}$	1303-96-4	-	10	30	38	
<b>Шинээр нэмэгдэж буй химийн бодисууд</b>									
26	Ammonium lignosulfonate	Аммонын лигносульфонат давс	-	8061-51-	-	100	300	50	
27	Calcium lignosulfonate	Кальцийн лигносульфонат давс	-	8061-51					
28	Sodium metabisulfite	Натрт метабисульфит	$\text{Na}_2\text{S}_2\text{O}_5$	7681 -57-4	-	100	300	50	
29	Calcium nitrite	Кальцийн нитрит	$\text{Ca}(\text{NO}_2)_2$	13780-06-8	-	130	390	10	
30	Calcium formate	Хөрс тогтворжуулагч ISS-1	-	7664-93-9 77-92-9 7664-38-2 104-55-2	3264	200	600	50	



#### 1.4 ХӨДӨЛМӨР АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

Тухайн химийн бодисын агуулахын ажилчид химийн бодистой ажиллах техник технологи сайн эзэмшсэн, аливаа осол гэмтэлд өртөхгүйгээр хэвийн үйл ажиллагаагаа тасралтгүй ажиллах аюулгүй орчин, анхны тусламжийн өрөө (Фото-зураг 1-4) болон таних тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан. Анхны тусламжийн өрөө нь ажилчдад эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх тоног төхөөрөмжөөр бүрэн тохижсон.



Фото-зураг 1-4. Анхны тусламжийн өрөө

Тус компани нь агуулахын ажилчдад хагас жилийн нормтой иж бүрдэл ажлын хувцас, улирлын нормтой хамгаалах бүс, хамгаалалтын хэрэгсэл бээлий, маск зэргийг тогтмол олгодог.



Фото-зураг 1-5. Аюулгүй ажиллагааны хамгаалалтын хувцас

Техник аюулгүй ажиллагааны болон үйл ажиллагааны зааварчилгааны талаар ажилчид зориулсан сургалт явуулдаг. Аваар ослын эрсдэлийг бууруулах үүднээс агуулахын талбай руу орох цэгүүдийг тодорхойлох, аюултай материал, бодис хадгалах зориулалтын агуулахыг бетонон гадаргуутай барих, талбайн ажилчдыг зохих сургаалтанд хамруулан аваарын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлж байна.

Барилгын дээврийн дотор талд гал унтраах зориулалттай автомат нунтаг гал унтраагуурыг (тунгус) агуулахын дээрийн дотор талд гурван эгнээгээр байрлуулсан.

## БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

**Физик газарзүй:** Төсөл хэрэгжих бүс нутгийн газар зүйн байршлын хувьд Монголын говь цөлийн бүсийн өмнөд хэсэгт байрладаг ба Ханбогд уулын орчимд орших говийн намхан толгодоос тогтох жинхэнэ цөлийн байгалийн бүс, бүслүүрт багтана.

**Уур амьсгал:** Майнинг Технологи Энд Экуйпмент ХХК-ийн хэрэгжүүлж буй Химийн бодис импортлох, худалдах, химийн бодисын агуулах төслийн 0.5 га талбай нь Монгол орны өмнөд цөлийн бүсэд орших бөгөөд энэхүү бүс нь далайн түвшнээс дээш 1000 гаруй метрийн өндөрт өргөгдсөн нам, үргэлжилсэн дов толгодтой тал газар бөгөөд Говийн жижиг (15- 50 метр) толгод болон (далайн түвшнээс дээш 1350 метрийн өндөрт орших Ханбогд уул) өндөр уулсаас тогтдог.

Говийн хахир хатуу уур амьсгалын нөхцөл байдал нь төслийн хэрэгжих нутгийн нийгэм, эдийн засагт ихээхэн нөлөөтэй. Температурын хазайц хэтэрхий эрс тэс, өвөлдөө хамгийн бага температур  $-34^{\circ}\text{C}$ -ээс бага, зуны улиралд ихэвчлэн  $40^{\circ}\text{C}$ -аас давж хална. Оюу Толгойн орд орчмын задгай тал хээр, хөндий, нам дор газар нь өвөлдөө хүйтэн, хур тунадас багатай, зэрэгцээ салхи ихтэй байдаг. Говьд их хуурайшилттай байдгаас тус газар нутагт цас бага унана. Өвлийн цагт агаарын температур  $-5^{\circ}\text{C}$ -аас  $-34^{\circ}\text{C}$  хооронд хэлбэлзэнэ. Хамгийн хүйтэн сар болох 1-р сард дундаж температур  $-12^{\circ}\text{C}$ , үнэмлэхүй бага температур  $-34^{\circ}\text{C}$  хүрнэ. Цас ихэнхдээ 5 см-ээс хэтрэхгүй зузаантай байна.

Хөрсний өнгөн давхаргын жилийн дундаж температур  $+8.8^{\circ}\text{C}$  байдаг ба зөвхөн өвлийн саруудад тэг хэмээс доошилдог байна. 11-р сараас 2 -р сар хүртэл хөрсний дундаж температур  $-3.6^{\circ}\text{C}$ -аас  $-13.2^{\circ}\text{C}$  хүртэл буурдаг ба 3 -р сараас 10 -р сар хүртэлх хугацаанд  $+0.3^{\circ}\text{C}$ -аас  $+29^{\circ}\text{C}$  хүрдэг. Зуны их халуун саруудад хөрсний гадаргуугийн температур  $+65^{\circ}\text{C}$  хүрдэг. Өвлийн цасан бүрхүүлтэй, хүйтэн өдрүүдэд хөрсөн дээр хамгийн бага температур  $-37^{\circ}\text{C}$  хүрдэг.

Агаарын харьцангуй чийгшил мөн адил хэлбэлзэл ихтэй байсан. 2010 оны 4-7 -р сарыг дуустал сарын дундаж харьцангуй чийгшил 28-35% байсан хэдий ч өдрийн дундаж агаарын харьцангуй чийгшил 5-95% байжээ. Өвөл, намрын улиралд сарын дундаж харьцангуй чийгшил 50-60%, өдрийн дундаж агаарын харьцангуй чийгшил 15- 90% байсан ба 8 -р сард харьцангуй чийгшил 27% болж буурсан байна. 2010 оны 3 -р сарын 20-нд хамгийн хуурай буюу 5% чийгшилтэй байдаг бол 9 -р сарын 17-нд борооны дараа агаар 100% чийгээр хангагддаг байна.

**Усан орчин:** Төслийн талбай дах уст давхаргууд нь газрын бага гүнд газрын гадаргаас 5 м орчим гүнд, харин газрын их гүнд орших уст давхаргууд 50 м-ээс доош гүнд оршдог байна. Бага гүнд орших гадаргуун түр урсацтай холбоотой уст давхаргууд орон нутгийн малчдын жилийн турш ашигладаг гар худаг, булгуудыг тэжээдэг тул чухал ач холбогдолтой юм. Газрын их гүний хэсэгчилсэн уст давхаргууд нь уурхайн талбайгаас зайтай оршдог ба энэхүү уст давхаргуудад төслийн үйл ажиллагаанд ашиглагдах усны хэрэгцээг хангах усны нөөц агуулагддаг байна.

**Хөрсөн бүрхэвч:** Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь Оюу Толгой төслийн тусгай зөвшөөрлийн талбайгаас 10 орчим км зайд оршино. Энэ орчмын тэгш газарт говийн цайвар бор хөрсний 7 төрөл, ухаа, гүвээ толгодын цайвар бор хөрсний 3 төрөл, нугат чийглэг цайвар бор хөрсний 2 төрлийн хөрс тархана.

**Ургамлан нөмрөг:** Төсөл хэрэгжих нутгийн ургамалжилт нь гадаргуугийн 5%-ийг эзлэх ба 0.5 метрээс илүүгүй өндөр, ганд тэсвэртэй олон наст сөөгүүдээс бүрдэнэ. Бүс нутагт хааяа тохиолдох Сибирийн хайлаас (*Ulmis pumilla*)-аас өөр мод ургадаггүй бөгөөд энэ нь голдуу улирлын шинж чанартайгаар Ундай голын голдирлын сав газраар ургадаг. Мөн ургамлан нөмрөг нь байгалийн анхдагч бүтээгдэхүүн гэдэг утгаараа нийгэм-эдийн засгийн холбогдолтой нөөц баялаг бөгөөд

ялангуяа энэ нь хөдөө аж ахуйн суурь хөгжилтэй манай орны хувьд бэлчээрийн ургац болон идэмжит чанараар тодорхойлогддог.

**Амьтны аймаг:** Төсөл хэрэгжих орчинд өмнө хийсэн судалгаагаар 43 зүйлийн хөхтөн тогтоогоод байгаа бөгөөд үүнд шавжаар хооллогч, сарьсан багваахай, туулай, мэрэгчид, махаар хооллогч амьтан, туурайтны аймаг орсон болно. Оюу Толгой орчимд 14 багийн, 33 овгийн, 65 төрлийн, 137 орчим зүйлийн суурин, өвөлждөг, нүүдлийн шувууд тэмдэглэгдээд байна. Төслийн талбай орчимд говь цөлд хатуу ширүүн улирлын нөхцөл болон хуурай болон хагас хуурай нөхцөлд дасан зохицсон цөөн хэдэн зүйл тархсан байна. Үүнд 8 зүйл гүрвэл, 5 зүйл могой тэмдэглэгдсэн байна. Оюу Толгой орчимд хийгдсэн судалгаагаар энэ орчимд 7 овгийн, 39 төрлийн 92 зүйлийн шавж бүртгэгдсэн байна. Хамгийн түгээмэл шавжийн зүйлд шулуун далавчтаны нэгэн анги болох *Bryodemis gebleri*, *Mongolocum Zub.*, *Locusta Migratoria* зэрэг багтана.

**Хүн ам, хүйсийн байдал:** Ханбогд сумын хүн амын 2016 онд 6387 байсан бол 2020 оны эцсийн байдлаар 8385 болж өссөн байна. Энэ нь уг сумын хүн амын тоо 2016-2020 онд 23.9 хувиар өссөн үзүүлэлт юм. Эдгээр онууд дахь Ханбогд сумын хүн амын хүйсийн бүтцийг харвал 2020 оны эцсийн байдал сумын нийт хүн амын 56.6 (4746) хувийг эрэгтэй, 43.4 (3639) хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

**Ажиллагсад:** 2020 оны байдлаар Өмнөговь аймагт дунджаар 28374 иргэн ажил үйлчилгээ эрхэлж байсан бол 2021 оны эхний улирлын байдлаар энэ тоо 27489 болж бага зэргийн буурсан байна. Өмнөговь аймагт нийт ажиллагсдын тоо 2020 оны 3-р улирлаас харьцангуй буурсан харагдаж байгаа бөгөөд эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудад өсөлт, болон бууралт гарсан байна. Эдгээрээс ажиллах хүчний тоогоор хамгийн их өсөлтийг харуулсан салбар бол барилга, бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарууд, хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагааны салбарт ажилтан нэмэгдсэн байна. Харин ажиллагсдын тоо буурсан салбарууд боловсруулах үйлдвэр, боловсрол, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарууд багтаж байна.

**Төсөв, санхүү:** Ханбогд сумын иргэдийн 2016-2020 онд хадгаламжийн байгууллагад байршуулсан хугацаатай, хугацаагүй болон нийт хадгаламжийн хувьд хадгаламжид байрших мөнгөн дүн 2018 оныг хүртэл өссөн ч 2019, 2020 онд буурсан үзүүлэлттэй байх ба 2020 оны байдлаар нийт хадгаламжийн хэмжээ 25,798.6 сая төгрөг байгаа бол үүний 68.3 хувь нь хугацаат, үлдсэн нь хугацаагүй хадгаламж байна.

Харин уг сумын иргэдийн зээлийн хэмжээ тэдгээрийн хадгаламжаас тогтмол давсан үзүүлэлттэй байгаа бөгөөд 2020 он гэхэд зээлийн хэмжээ огцом өсөж 63200 сая төгрөгт хүрсэн бөгөөд энэ нь нийт хадгаламжийн хэмжээнээс 2.4 дахин их байсан байна.

**Мал аж ахуй:** 2019 онд Ханбогд сум нь нийт 573 малчин, 390 малчин өрх нийт 190030 тоо толгой малтай байсан бол 2020 онд эдгээр үзүүлэлтүүдээс малчдын тоо 640, малчин өрхийн тоо 400, малын тоо 200560 болж тус тус өссөн үзүүлэлттэй байна. Малын тоо толгойн хувьд бүх багт өссөн үзүүлэлттэй байгаа ба Жавхлант багийн малын тоо толгой 2019 оноосоо 9.7 хувиар, Гавилууд баг 2.6 хувиар, Номгон баг 5.5 хувиар, Баян баг 3 хувиар, Хайрхан баг 19.8 хувиар өссөн байна.

### БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Майнинг технологи энд экуйпмент ХХК-ийн Химийн бодисын агуулах төслийн БОННУ-ээр төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Хүснэгт 3-1 Нөлөөллийн үнэлгээ

Байгаль орчны үзүүлэлтүүд	Нөлөөлөх байдал		Хугацаа		Чиглэл			Эрчим		
	Шууд	Шууд бус	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Өөрөө зохицуулагдах	Бага	Дунд	Хүчтэй
<b>1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт</b>										
Гадаргын усны урсцын өөрчлөлт										
Гадаргын усны чанарын өөрчлөлт		x		x		x		x		
Ой, ургамлын бүтцийн өөрчлөлт	x			x			x	x		
Хөрсний элэгдэл, эвдрэл	x			x		x			x	
Геологийн тогтцын өөрчлөлт		x	x					x		
Зэрлэг амьтдын оронзайн өөрчлөлт	x			x				x		
Уур амьсгалын /бичил/ өөрчлөлт	x			x		x			x	
<b>2. Байгалийн нөөц ашиглалт</b>										
Газрын гадаргын нөөц баялаг	x			x		x		x		
Бэлчээр, тэжээлийн байдал	x			x			x	x		
Эрдэс түүхий эдийн нөөц /ус/		x		x			x	x		
Эрчим хүчний нөөц	x			x		x		x		
<b>3. Байгаль, орчны өөрчлөлт</b>										
Ундны усны чанар, хэмжээ	x			x		x		x		
Урсгал усны нөөцийн горим										
Агаарын бохирдол	x			x		x		x		
Хөрсний, бохирдол элэгдэл	x			x			x		x	
Хорт бодис хүн, амьтанд нөлөөлөх	x			x		x				x
Дуу чимээний нөлөөлөл	x			x				x		
<b>4. Нийгэмд үзүүлэх нөлөөлөл</b>										
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	+			+		+		+		
Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх		+		+		+		+		
Хүн амын орлого өөрчлөгдөх	+			+		+		+		
Хүн амын эрүүл мэнд, соёл	+			+	+			+		
<b>5. Эдийн засаг, нийгмийн асуудал</b>										
Татварын орлого өөрчлөгдөх	+			+	+			+		
Орон нутгийн орлог өөрчлөгдөх	+			+		+		+		
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	+			+		+		+		
Ажлын байр нэмэгдэх	+			+		+		+		
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+		+					+		

6. Бусад нөлөөлөл										
Ахуйн бохир уснаас хөрс, газрын доорх ус бохирдох	x		x				x	x		
Химийн бодис асгарах, алдагдах	x			x	x				x	
Галын аюулгүй алдагдах	x		x		x					x
<b>Дүн</b>	<b>23</b>	<b>4</b>	<b>4</b>	<b>23</b>	<b>4</b>	<b>14</b>	<b>5</b>	<b>21</b>	<b>6</b>	<b>2</b>

*Тайлбар: "x" сөрөг нөлөөлөл, "+" эерэг нөлөөлөл*

Хүснэгтээс үзвэл байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөллийн нийт тоо 27 байна. Нөлөөллийн байдлыг доор үзүүлэв. Үүнд:

**Шууд нөлөөлөл.** Энд болзошгүй нөлөөллийн ихэнх нь шууд нөлөөлөлд хамрагдаж байна. Төслийн явцад тодорхой хэмжээгээр хөрсний эвдрэл гарах, үүний улмаас ургамлын бүтцийн өөрчлөлт гарч болзошгүйгээс гадна ундны усны чанар, хэмжээ болон агаарын чанарт бага зэргийн сөрөл нөлөө үзүүлэх талтай.

**Шууд бус нөлөөлөл.** Хүн болон техникийн хөдөлгөөн ихсэх, эзэмшил газрын гадаргын тогтоц өөрчлөгдөн хотгор гүдгэрийн сөрөг хэлбэрүүд үүсэх, хог хаягдлыг удаан хугацаагаар хадгалах болон автомашины төвлөрлөөс шалтгаалан агаар, хөрс бохирдох нөлөөлөл зэрэг нь шууд бус сөрөг нөлөөлөлд хамаарч байна.

**Богино хугацааны нөлөөлөл.** Үүнд зөвхөн төслийн үйл ажиллагаанаас болон барилга, байгууламж нэмж барих тохиолдолд өнгөн хөрсний бохирдол ба эвдрэл, агаарын бохирдол түр зуур гарах зэрэг нөлөөлөл хамаарна.

**Урт хугацааны нөлөөлөл.** Төслийн үйл ажиллагаа удаан хугацаагаар үргэлжлэх учир байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн ихэнх /85.2%/ нь урт хугацаанд экологийн тогтолцоонд бүгд буцалтгүй нөлөөлөхөөр байна. Үүнд үйл ажиллагааны улмаас орчны, гадаргын хэлбэр, ургамлын бүрхэц, бичил уур амьсгал өөрчлөгдөх эрчим хүчний хэрэглээний өсөлт гарах, дуу чимээ нэмэгдэх зэрэг сөрөг нөлөөллүүдээс гадна, орон нутгийн эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөллүүд хамаарч байна.

**Нөлөөллийн эрчим.** Төслийн нийт нөлөөллийг эрчимшлээр нь авч үзвэл, 72.4% нь сул болон сулавтар, 20.7% нь дунд зэрэг, 6.9% нь их зэрэгт багтах нөлөөлөл байна. Нийт нөлөөллийн 17 нь сөрөг байхаар байна.

## БҮЛЭГ 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (2023 ОН)

### 4.1 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Майнинг технологи энд экүйпмент ХХК-ийн Химийн бодисын агуулах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллахыг зорьж байна.

### 4.2 2023 ОНЫ БОМТ-НИЙ ЗАРДЛЫН ХУРААНГУЙ

Химийн бодисын агуулах төслийн 2023 оны БОМТ-г Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу боловсрууллаа. 2023 оны тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх нийт зардал нь дунджаар 9.56 сая төгрөг байхаар тооцлоо.

Хүснэгт 4-1. Химийн бодисын агуулахын 2023 оны БОМТ-ын хэрэгжилтийн зардал

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт зардал (сая ₮)	
1	Сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээний төлөвлөгөө	1.36	
	Орчны тохижилтын төлөвлөгөө	1.06	
	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1.36	
	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	3.5	
	Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	0.825	
2	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1.16
3	БОМТөлөвлөгөөг оролцогч, сонирхогч талд тайлагнах	0.3	
<b>Нийт зардал</b>		<b>9,565</b>	

### 4.3 2023 ОНЫ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 4-2. 2023 оны тухайн жилийн сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, сая ₮	Тоо хэмжээ	Нийт зардал, сая ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
<b>Агаарын чанар</b>									
1	Химийн бодисыг тээвэрлэх тээврийн хэрэгслийн хөдөлгөөний улмаас агаарт хорт хий, тоос агаарт хаяж, агаарын чанарт сөргөөр нөлөөлөхөөр байна.	Тоос, шороо ихээр боссон тохиолдолд засмал замаас төслийн талбай хүртэлх шороон замыг услах, чийгшүүлэх	Төслийн талбай орчим	гүйцэтгэл	0.02	4-9 сард 18 удаа	0.36	Тоос шороо ихээр боссон үед	MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS 6063:2010 “Агаарын чанар – Хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ” MNS 4990:2000 “ХААЭА. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага”. MNS 6757 : 2019
2	Агааржуулалтын системд гэмтэл, доголдол гарч, хадгалалтын горим алдагдах	Агааржуулалтын ажиллагаа хэвийн байгаа эсэхэд урьдчилсан шалгалт үзлэг тогтмол хийх	Химийн бодисын агуулахын агааржуулах системд	гүйцэтгэл	-	Сард 2 удаа	Хариуцсан ажилтны цалинд тооцогдох	Үйл ажиллагааны туршид	
<b>Хөрсөн бүрхэвч (газрын гадарга)</b>									
3	Машин техникийн аюулгүй ажиллагаа алдагдан шатах тослох материал асгарах, улмаар саармагжуулаагүйн улмаас хөрсөнд нэвчин хөрсний ус, гүний усыг бохирдуулж болзошгүй	Асгаралт болсон тохиолдолд ашиглах асгарлын иж бүрдлийг бэлэн байлгах, хэрэглэсэн тохиолдолд нөхөн сэлбэх	Төслийн талбайн хүчилтгүй хэсэгт	ширхэг	0.5	2 удаа	1.0	2023 оны 2-р удиралд багтаан	Агуулахад хагдгалагдаж буй бодисуудын Хор Аюулгүйн Лавлагааны дагуу
4	Хөрсний ус, гүний усыг бохирдуулж болзошгүй	Асгаралт болсон тохиолдолд хэрхэх талаар ажилчдад сургалт зохион байгуулах	Төслийн талбайн хүчилтгүй хэсэгт	гүйцэтгэл	0.3	1 удаа	-	Шинэ ажилтан авах бүрд	Энгийн хог хаягдлыг хаягдлын санд цуглуулахдаа Хог хаягдлын тухай хуулийн 15 дугаар зүйл. Хогийн саванд тавигдах шаардлагад нийцүүлэн ангилах, ачих цуглуулах технологид нийцсэн, ус хуримтлагдах, анион турш
5	Химийн бодисын асгаралтын улмаас хөрсөн	Химийн бодисуудын ХАЛМ (MSDS)-ыг тээвэр	Төслийн талбайд	гүйцэтгэл	-	-	Хариуцсан ажилчдын	Бүх үйл ажиллагааны турш	

	бүрхэвч бохирдох, хөрсний микроорганизмд нөлөөлөх	хийх жолооч нарт танилцуулах					цалинд тооцогдох		шүүрэл ялгарахаас сэргийлсэн байдлаар байгуулах
<b>Усны нөөц</b>									
6	Ахуйн хэрэглээнээс гарсан бохир ус, хог хаягдлыг ил задгай хаях, улмаар хур борооны усаар угаагдсан гүний усыг бохирдуулах	Ахуйн хог хаягдлыг ангилан хаяж, тогтмол тээвэрлүүлэх	гүйцэтгэл	-	-	1 удаа	Хариуцсан ажилтны цалинд тооцогдох	Үйл ажиллагааны туршид тогтмол	Хог хаягдлын тухай хууль Өмнөговь Аймгийн ИТХ 2019 оны 9/8 дугаар тогтоолын Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах устгах, булшлах журам
7	Байгаль орчныг хамгаалах тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд сумын Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж буй аливаа үйл ажиллагаанд идэвхитэй оролцох /Байгаль хамгаалах хавар, намрын сарын аян, Цөлжилттэй тэмцэх өдөр, Дэлхийн усны өдөр, Дэлхийн нүүдлийн шувуудын өдөр, Биологийн олон янз байдлыг хамгаалах өдөр гэх мэт /	Зохион байгуулж буй үйл ажиллагаанд оролцох	гүйцэтгэл	-	-	1 удаа	Хариуцсан ажилтны цалинд тооцогдох		
<b>Ургамлан нөмрөг</b>									
8	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр ургамлан нөмрөг талхлагдах, машин техникээс ялгарах тоос тортог ургамлан нөмрөгийг халхалж фотосинтезийг бууруулна	Олон салаа зам гаргахгүй, тогтсон нэг замаар зорчих, Тээврийн хэрэгслийн үзлэг оношилгоо, засвар үйлчилгээг тогтмол хийх	гүйцэтгэл	-	-	1 удаа	Хариуцсан ажилтны цалинд тооцогдох	Үйл ажиллагааны туршид тогтмол	Байгаль Орчин, Аялал Жуулчлалын сайд, Эрүүл Мэндийн сайд, Онцгой Байдлын Ерөнхий Газрын даргын 2009 оны 02 сарын 03-ны өдрийн 28/40/29 дүгээр хамтарсан тушаалаар баталсан Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам
9	Химийн бодисыг импортлон тээвэрлэх тээврийн хэрэгслийн хөдөлгөөний нөлөөллөөр зам дагуух	Химийн бодисыг тээвэрлэхдээ шороон замаар 30 км/цаг, хатуу	гүйцэтгэл	-	-	1 удаа	Хариуцсан ажилтны цалинд тооцогдох	Үйл ажиллагааны туршид	Баталсан Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам



	хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг талхлагдах	хучилттай замаар 60 км/цагийн хурдтай явах						тогтмол	
<b>Амьтны аймаг</b>									
10	Хог хаягдлыг ил задгай цуглуулснаас мал амьтад тэжээл хайж ирэх орогнох, хордож болзошгүй	Хог хаягдлыг ангилан зориулалтын битүү саванд байршуулах, битүүмжлэлийг байнга хянаж шалгах	Төслийн талбайн хаягдлын цэгт	Хог хаягдлын МТ-нд тусгагдсан					
<b>Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний нийт зардал</b>							1.36 сая төгрөг		

**Хөрөнгө санхүүгийн эх үүсвэр:** Жил бүрийн санхүүгийн төлөвлөгөөний байгаль орчны болон ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээний зардалд тусган зарцуулж байх шаардлагатай. Төлөвлөсөн зардлын хэмжээ нь тухайн жил бүр харилцан адилгүй тогтоогдох боломжтой тул тухай бүрд нь тодруулга хийж шинэчлэн тооцно.

#### 4.3.1 Орчны тохижилтын төлөвлөгөө

2023 онд Майнинг технологи энд экуйпмент ХХК-ийн Химийн бодисын агуулах төслийн талбайд тариалсан моднуудын ургалтыг дэмжиж, усалгаа, бордолтыг тогтмол хугацаанд хийнэ. Энэ үйл ажиллагааг авч хэрэгжүүлэхэд 1060,000.0 төгрөг зарцуулах тооцоолол гарсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар зохион байгуулагдах “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”, Өмнөговь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 56 дугаар тогтоолоор батлагдсан “Тонн баялаг- Нэг мод” тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Ханбогд сумын ЗДТГазартай хамтран ажиллах ба зааж өгсөн байрлалд 100 ш мод шинээр тарьж ургуулна.

Хүснэгт 4-3. 2023 оны орчны тохижилтын төлөвлөгөө

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
1	2	3	4	5	6	7	8
Төслийн талбайд тариалсан хайлаасны суулгацуудыг арчилж, ургалтыг дэмжих	Байгуулсан ногоон байгууламжийн ургалтыг дэмжих	Ногоон байгууламжид	удаа	18	10.0	180.0	5-8 сар, сар бүр 3 удаа
Ургалтыг дэмжиж, хөрсийг бордох			кг	8	10.0	80.0	Ургалтын улиралд 1 удаа
Ханбогд сумын ЗДТГазартай хамтран ажиллах ба зааж өгсөн байрлалд 100 ш мод шинээр тарьж ургуулна.			Ш	100	8,0	800.0	Ургалтын улиралд 1 удаа
Нийт зардал					1060,000.00 төгрөг		

#### 4.3.2 Нүүлгэн суурьшуулах арга хэмжээний төлөвлөгөө

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байрлах Майнинг технологи энд экуйпмент ХХК-ийн Химийн бодисын агуулах төслийн 0.5 га талбай нь тус компанийн эзэмшлийнх бөгөөд уг талбайд суурьшсан иргэд, айл өрхүүд байхгүй тул нүүлгэн суурьшуулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах шаардлагагүй гэж үзлээ.

#### 4.3.3 Соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Химийн бодисын агуулахын төслийн цаашид үйл ажиллагааны явцад соёлын өв олдсон тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30.4-т заасны дагуу олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор сум, дүүргийн бүртгэл мэдээллийн санд заавал бүртгүүлнэ.

#### 4.3.4 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

2021-2025 оны БОМТ-г үндэслэн 2023 оны осол эрсдэлийн үнэлгээ болон тэдгээрээс урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг доорх хүснэгтэд боловсрууллаа.

Хүснэгт 4-4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
1	2	3	4	5	6	7	
1	Аянга цахилгаан	Аянга зайлуулагчийн хэвийн ажиллагаанд мэргэжлийн байгууллагаар шалгалт хийлгэх	Төслийн талбайн аянга газардуулагч бүр	1	300,000.0	300,000.0	2023 оны 2-р улиралд, 1 удаа
2	Аадар бороо, үер	Цаг агаарын нөхцөлийг харгалзан үзэж, хамгаалалтын суваг шуудууны бүрэн бүтэн байдалд хяналт тавих; хүмүүст үерийн анхааруулга өгч хүний амь нас, дэд бүтцийг хамгаалах	Төслийн талбайд байрлах суваг, шуудуунд	3	-	Хариуцсан ажилтны цалинд тооцогдох	Борооны улиралд, сард 2 удаа
3	Шороон шуурга	Онцгой байдлын журам боловсруулан мөрдөж ажиллах	Төслийн үйл ажиллагаанд	-	-		
4	Халдварт өвчин	Өндөр эрсдэлтэй амьтадтай (шувууд) харьцахгүй байх хангалттай хэмжээний хамгаалалтын хэрэгсэлтэй байх (амны хаалт, гар ариутгагч гэх мэт)	Төслийн ажилчид	2 хүнд	30,000.0	60,000.0	2023 оны 1-р улиралд багтаан
5	Шатах тослох материалын асгарал	Ашиглалт, тээвэрлэлт, хадгалалт зэрэгт анхаарал хандуулж холбогдох журам боловсруулан мөрдөж ажиллах шаардлагатай.	Төслийн үйл ажиллагаанд	-	-	Хариуцсан ажилтны цалинд тооцогдох	2023 оны 2-р улиралд багтаан
6	Хөдөлмөр хамгааллын дүрэм алдагдах, ажилчдын эрүүл мэнд нөлөөнд өртөх	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах	Төслийн ажилчдад	8 хүн	100,000.0	1000,000.0	2023 оны 3-р улиралд багтаан
<b>Нийт</b>						<b>1.360.000.00 төгрөг</b>	

#### 4.3.5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

2023 оны Майнинг технологи энд экуйпмент ХХК-ын хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг доорх хүснэгтэд үзүүллээ. Хог хаягдлын сөрөг нөлөөлөл болон түүний хэмжээг бууруулахад тус онд **3 сая 500 мянган төгрөг** төсөвлөлөө.

Энгийн хог хаягдлын тухайд доорх зөвлөмжүүдийг баримталж ажиллана. Үүнд:

- Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 9/8 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах устгах, булшлах журмыг баримталж ажиллах
- Төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг ангилан ялгаж, уг тайлангийн Лавлагаа хэсэгт жишээгээр үзүүлсэнтэй адил 3 тасалгаат хогийн саванд хадгалах,
- Хогийн савнуудын битүүмжлэл, бүрэн бүтэн байдлыг хангах
- Хог хаягдлыг зохистойгоор хаяж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажлын байрны шалгалт тогтмол явуулах, ажилчдад заавар зөвлөмж өгөх
- Хогийг анхан шатанд нь ангилан, ялгаж дахин ашиглах боломжтой хог хаягдлын хувь хэмжээг нэмэгдүүлэх
- Төслийн талбай дах хог хаягдлын нэгсэн цэг болон бие засах газрыг тогтмол ариутгах
- Орон нутагт жижиг, дунд бизнесийг дэмжих зорилгоор хог хаягдлыг тээвэрлэх, устгах зэрэг ажлуудыг гүйцэтгэх орон нутгийн компани, сумын удирдлагатай хамтарсан гэрээ байгуулан хог хаягдлыг тогтмол хугацаанд тээвэрлэж байх
- Ханбогд сумаас зохион байгуулж буй бүх нийтийн хог цэвэрлэгээнд идэвхитэй оролцох

Аюултай хог хаягдлын тухайд доорх зөвлөмжийг баримталж ажиллана. Үүнд:

- Химийн бодисын сав баглаа боодол, асгарлын хаягдал гарсан бол Хог хаягдлын тухай хуулийг баримталж ажиллах,
- Бүрэн цэвэрлээгүй шатах тослох материалын болон химийн бодисын сав баглаа боодлыг аюултай хог хаягдал гэж үзэх тул “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам”-ыг мөрдөнө
- БОАЖСайдын 2018 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн тушаалаар батлагдсан Аюултай хог хаягдал үүсгэгчийн тайлангийн маягтын дагуу тайлан бүртгэлийг хөтлөх
- Мөн дээрх тушаалын 1-р хавсралтаар батлагдсан Аюултай хог хаягдлын дагалдах бичгийг бүрэн гүйцэт бөглөж байх шаардлагатай

Хүснэгт 4-5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, сая төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1	Ахуйн	Төслийн талбайн хогийн нэгдсэн цэгт тогтмол ариутгал, цэвэрлэгээ хийх	Төслийн талбайн хогийн сав	Удаа	0.1	4	0.4 сая ₮	Улирал бүр	Хог хаягдлын тухай хууль (Шинэчилсэн найруулга), Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 11 дүгээр сарын 17 өдрийн А/443 дугаар тушаалын хавсралт Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, Дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага MNS 5344 : 2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага Өмнөговь Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 9/8 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт: Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах,
2		Төслийн байгууламжуудын хогны савуудыг хог хаягдлын уугаар хангаж, хог ил задгай хаяхгүй байх, ил задгай бие засахгүй байх санамж, зааварчилгааг тогтмол өгөх	Төслийн талбай	Гүйцэтгэл	Тодорхойлох боломжгүй	-	Тодорхойлох боломжгүй	Тогтмол	
3		ААНБ нь батлагдсан маягт болон “эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт”-ын дагуу хог хаягдлын тоо бүртгэлээ тухай бүр хөтөлж, журмаар тогтоосон хугацаанд тайлангаа сумын Засаг даргад хүргүүлэх	Төсөл хэрэгжүүлэгч	Нэгж тайлан	Гүйцэтгэгч ажилтны цалинд бодогдох	Улиралд 1 удаа	Дотоод зардалд тусгах	Улирал бүр	
4		Ажиллагсдын хэрэглээнээс гарах хог хаягдлыг нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлэн, тусгай зөвшөөрөл бүхий байгууллагатай гэрээ хийж Ханбогд сумын нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлэх	Тухайн байршил	удаа	0.05	12	1.8 сая ₮	Сард 1 удаа	
	Бохирын	Ажилчдын хэрэглээнээс гарах бохирыг соруулах	Төслийн талбай	удаа	0.3	2	0.8 сая ₮	Хагас жилд 1 удаа (бохирын цооногийн	

								дүүрэлтээс хамаарна)	сэргээн ашиглах устгах, булшлах журам
6	Аюултай	Авто машин, машин механизмуудад хэрэглэсэн тос тосолгооны сав, цэвэрлэгээний бодис, эд анги дугуй зэрэг хог хаягдал гарсан тохиолдолд тэдгээрийг хаялгүйгээр хадгалж бүртгэл хөтлөх. Зориулалтын аргаар мэргэжлийн байгууллагын зөвлөмжийг үндэслэл болгон тээвэрлүүлэх буюу бусад шаардлагатай арга хэмжээг авах	Төслийн талбай	кг	-	Хог хаягдлын хэмжээ	-	Төслийн үйл ажиллагааны түршид	MNS 4978 : 2017 Аюултай ачаа. Ангилал. Тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, Тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам
7		Гэнэтийн осол эрсдэл зэргээс шалтгаалан химийн бодисын сав баглаа боодолд гэмтэл гарч, асгарал үүссэн тохиолдолд химийн аюултай хортой хог хаягдал гарах бөгөөд энэ хаягдлыг түр хугацаанд хадгалж байгаад эрх бүхий аж ахуй нэгжээр тээвэрлүүлэх зардлыг дансанд төвлөрүүлж байнга бэлэн байлгах	Төслийн талбай	кг	2.5	Хог хаягдлын хэмжээ	0.5	Аюултай хог хаягдал гарсан тохиолдолд	Тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам
<b>Нийт</b>					<b>3.500,000.00 төгрөг</b>				

#### 4.3.6 Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Майнинг технологи энд экуйпмент ХХК-ийн Химийн бодисын агуулах төслийн явцад байгаль хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахтай холбоотой арга хэмжээг тухай бүрд авч хэрэгжүүлэх шаардлагатай. Газрын төлөв байдлын хянан баталгааг 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэх хэрэгтэй. Төслийн үйл ажиллагааны 2 жил тутамд Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг холбогдох мэргэжлийн байгууллагаар хийх нь зүйтэй юм.

Хүснэгт 4-6. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, 2023 он

#	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	2022 оны хэрэгжүүлэлтийн хуваарь	Хариуцсан албан тушаалтан
	1	2	3	4
1	Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэлийн дагуу хог хаягдлын төрөл, кодыг тогтоон ялгаж бүртгэл хөтлөх	Хариуцсан ажилтны цалинд тооцогдох	Тогтмол	БОМ
2	Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлын талаар мэдлэг олгох, гал түймэр, усны аюул, мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаарх сургалтыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран 3 жил тутамд зохион байгуулах	500 мян.₮	2-3 дугаар улиралд багтаан	Удирдлага, ХАБ
3	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах, нөхөн сэлбэх	Үйл ажиллагааны зардалд тусгах		
4	Аюул, ослын үед ажиллах төлөвлөгөөг боловсруулж, байгууллагын удирдлага болон орон нутгийн онцгой байдлын газраар батлуулна	Үйл ажиллагааны зардалд тусгах		
5	Химийн хорт болон аюултай бодистой харьцаж ажиллагчдад аюулгүй ажиллагаа, болзошгүй осол, эрсдэлээс сэргийлэх болон анхны тусламж үзүүлэх сургалтыг зохион байгуулах	Осол эрсдэлийн МТ-нд тусгагдсан		
6	Төслийн талбайд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, техник ашиглалтын талаарх мэдээлэл бүхий самбарыг байршуулах, мэдээллийг цаг тухай бүрд нь шинэчилж байх	325 мян.₮	1 дүгээр улиралд багтаан	ХАБ
<b>Нийт</b>		<b>825 мян төгрөг</b>		

**Хөрөнгө санхүүгийн эх үүсвэр:** Жил бүрийн санхүүгийн төлөвлөгөөний уурхайн байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардалд тусган зарцуулж байх шаардлагатай. Төлөвлөсөн зардлын хэмжээ нь тухайн жил бүр харилцан адилгүй тогтоогдох боломжтой тул тухай бүрт нь тодруулга хийн шинэчлэн тооцно

#### 4.4 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зааснаар Химийн бодисын агуулах төслийг хэрэгжүүлэхдээ тухайн дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг төсөл хэрэгжүүлэгч Майнинг технологи энд экуйпмент ХХК-д өгөгдсөн. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсан байна. Хуулийн дээрх заалтыг удирдлага болгон төслийг хэрэгжүүлэх явцад “Цагаан дэлгэрэх өргөө” ХХК-аас байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон Байгаль орчин ногоон хөгжлийн яамны сайдын 2014 оны 04-дүгээр сарын 10 ны өдрийн А-117 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, “Байгаль орчны стратегийн болон хуримтлах нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ийн 4-р хэсэг болох Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлалд заасны дагуу байгалийн бүрдэл тус бүрээр энэхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг (ОХШХ) боловсруулав.



Хүснэгт 4-7. 2023 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтам-жийн тоо	Нэгж зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	2	3	4	5	6	7	8	
<b>Агаарын чанар</b>								
1	PM 10 болон PM 2.5 тоосонцор	Агуулахын дотоод орчны агаар	2023 оны 3 дугаар улиралд	1	190 мян.₮	190 мян.₮	Хөндлөнгийн хяналт шинжилгээ	MNS 0012-068:1991 Ажлын байрны агаарт байгаа азотын давхар ислийг тодорхойлох арга MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4585:2007 Хот, суурины агаарт химийн хорт бодис байхыг зөвшөөрөх дээд хэмжээ
2	Гадаад орчны агаарын тоосжилт PM 10 болон PM 2.5 тоосонцор	Агуулахын гадаад орчны агаар		1	170 мян.₮	170 мян.₮	Дотоодын хяналт шинжилгээ	MNS 3113:1981 Агаар мандал. Агаарын бохирдуулах бодисыг тодорхойлох аргад тавигдах ерөнхий шаардлага. MNS 0017-2-3-16:1988 Хот суурин газрын агаарын чанарыг хянах журам. MNS 5013:2003 Бензин хөдөлгүүртэй автомашин – Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга
<b>Усан орчин</b>								
3	Физик хими, нянгийн бүрэн шинжилгээ, Хүнд металлын шинжилгээ, БХХ усны стандартад заасан үзүүлэлтүүд	Ажилчдын ус хангамжийн худаг	2023 оны 3 дугаар улиралд	1	100 мян.₮	100 мян.₮	Хөндлөнгийн хяналт шинжилгээ	MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Хаягдал ус. Ерөнхий шаардлага
<b>Хөрсөн бүрхэвч</b>								
4	Ялзмаг, урвалын орчин (pH), давсжилт, карбонат (CaCO <sub>3</sub> ), хөдөлгөөнт кали (K <sub>2</sub> O),	Агуулах орчимд хатуу хучилтгүй талбай, хогийн цэг	2023 оны 3	1	500 мян.₮	500 мян.₮	Хөндлөнгийн хяналт шинжилгээ	MNS 3297:2019 “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний эрүүл

	хөдөлгөөнт фосфор (P <sub>2</sub> O <sub>5</sub> ), Шингээгдсэн сууриуд Ca, Mg	орчимд, бие засах газрын ойролцоо	дугаар улиралд						ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх”, MNS 4920:2000 “Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ”, MNS 2305:1995 Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам, MNS 3298:1991 Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
5	Механик бүрэлдэхүүн, чулуу, чийг, амь чийг, эзлэхүүн жин	(Нийт 3 цэгт)							
6	Хар тугалга (Pb), кадмий (Cd), хром (Cr), цайр (Zn), никель (Ni), Мөнгөн үс (Hg), Хүнцэл (As),	Агуулах орчимд хатуу хучилтгүй талбай, тээврийн машин зорчих замын хажуу – хучилтгүй талбайгаас (Нийт 2 цэгт)	2023 оны 3 дугаар улиралд	1	200 мян.₮	200 мян.₮	Хөндлөнгийн хяналт шинжилгээ		
<b>2022 онд орчны хяналт шинжилгээ хийхэд зарцуулагдах урьдчилсан байдлаар тооцсон зардал</b>						<b>1,160,000.00</b>			

**Хөрөнгө санхүүгийн эх үүсвэр:** Жил бүрийн санхүүгийн төлөвлөгөөний уурхайн байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардалд тусган зарцуулж байх шаардлагатай. Төлөвлөсөн зардлын хэмжээ нь тухайн жил бүр харилцан адилгүй тогтоогдох боломжтой тул тухай бүрт нь тодруулга хийн шинэчлэн тооцно

#### 4.5 БОМТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ

Төсөл хэрэгжүүлэгч “Майнинг технологи энд экуйпмент” ХХК 2023 онд тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайланг хүргүүлэх ба төсөл хэрэгжих аймгийн байгаль орчны газар, сумын Засаг даргын тамгын газарт тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлнэ.

Хүснэгт 4-8. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

№	БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, сая төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7	
1	Байгаль Орчин, Аялал Жуулчлалын яам	Тайлангийн эх хувь болон цахим хэлбэрээр албан бичгийн хамт	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр илэрхийлэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна	11 дүгээр сарын 30-ний дотор	0.3 сая ₮	Удирдлага болон Байгаль орчны мэргэжилтэн	УБ хот
2	Өмнөговь аймгийн байгаль орчны газар		11 дүгээр сарын 01-ээс өмнө	Өмнөговь аймаг			
3	Ханбогд сумын Засаг даргын тамгын газарт		11 дүгээр сарын 01-ээс өмнө	Ханбогд сум			
<b>Нийт</b>			<b>300,000.00 төгрөг</b>				